

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, НӨХӨН ХАНГАЛТЫН ТАЛААР АЛБА ХААГЧДААС
АВСАН СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮНГИЙН ТАЛААР**

Алба хаагчдаас авсан судалгаа нь бүтцийн хувьд анкетын хэсэг, чөлөөт асуулт хариулт болон 9 бүлэг, 20 асуулттай бөгөөд судалгааг Google forms флатформ ашиглан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын мэдээллийн санд 14 хоногийн хугацаанд байршуулан, чөлөөт хэлбэрээр авсан. Судалгаанд алба хаагчдын цол нэр, цахим хаягийн мэдээллийг агуулаагүй, эх сурвалжийг нууцалсан болно.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдын ерөнхий мэдээлэл:

Судалгаанд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын 3281 алба хаагч хамрагдсанаас 1482 буюу нийт алба хаагчдын 45,2 хувийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад ажилладаг алба хаагчид эзэлж байна. Насны хувьд авч үзвэл 26-41 настай алба хаагчид 70,4 хувийг эзэлж, хүйсийн хувьд 84,1 хувь нь эрэгтэй, ажилласан ажил, туршлагын хувьд 5 жил хүртэлх хугацаанд ажилласан алба хаагч нийт судалгаанд оролцогчдын 38,5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан алба хаагчдын мэдээлэл, жагсаалт:

Үзүүлэлт	Шинж байдал	Тоо	Хувь
Харьяа байгууллага	Цагдаагийн төв байрны газар, хэлтэс, нэгж	845	25,8
	Харьяа алба, нэгж	694	21,2
	Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага	1482	45,2
	Дотоодын цэргийн штаб, анги салбар	203	6,2
	Бусад	57	1,7
Чиг үүрэг	Захиргаа /төлөвлөлт, хүний нөөц/	281	8,6
	Санхүү хангамж	112	11,2
	Эрүүгийн цагдаа	328	32,8
	Мөрдөн байцаах	114	11,4
	Зөрчил шалгах	60	1,8
	Хэв журмын ажилтан	1213	37
	Замын цагдаа	340	10,4
	Дотоодын цэрэг	189	5,8
	Инженер, техник	80	2,4
	Бичиг хэрэг, архив	44	1,3
	Бусад	520	15,8
Албан тушаалын байдал	Удирдах албан тушаал	125	3,8
	Ахлах офицерын албан тушаал	416	12,7
	Дунд офицерын албан тушаал	1021	31,1
	Ахлагч бүрэлдэхүүний албан тушаал	1705	52
	Энгийн ажилтан	14	0,4
Нас	18-25	604	18,4
	26-33	1125	34,3
	34-41	1184	36,1
	42-49	348	10,6

	50 ба түүнээс дээш	20	0,6
Хүйс	Эрэгтэй	2760	84,1
	Эмэгтэй	521	15,9
Цагдаагийн байгууллагад ажилласан жил	0-5 жил	1262	38,5
	6-10 жил	689	21
	11-15 жил	626	19,1
	16-20 жил	574	17,5
	21-25 жил	109	3,3
	26 ба түүнээс дээш	21	0,6

Нэг. Цагдаагийн алба хаагчдын сэтгэл ханамжийн түвшин:

Цагдаагийн алба хаагчдын үүргээ шударгаар биелүүлж, үр дүнтэй ажиллах эсэх нь тэдний албандаа хандах хандлага, итгэл үнэмшилтэй салшгүй холбоотой. Алба хаагчдын сэтгэл ханамжид цагдаагийн байгууллага, түүний удирдлагын бодлого шийдвэр, алба хаагчдын өөрсдийнх нь хууль ёсны эрх ашгийг хамгаалж буй байдал, тэдний үүргээ гүйцэтгэх баталгаа, хүний нөөцийн томилгоо, шагнал урамшуулал, удирдлагын манлайлал зэрэг олон талт үйл ажиллагаа нөлөөлдөг байна.

1.1. Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын хүний нөөцийн сонгон шалгаруулалт, нөхөн хангалтын талаар алба хаагчдын сэтгэл ханамжид өгсөн үнэлгээ:


Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалт, нөхөн хангалтын талаар алба хаагчдаас 2 төрлийн асуултаар тандаж, үр дүнг нэгтгэхэд 3,25 оноо буюу сэтгэл ханамжийн түвшин “дундаж” үнэлгээтэй гарсан байна. Энэхүү 2 төрлийн асуултад судалгаанд оролцсон нийт алба хаагчдын 523 нь “огт санал нийлэхгүй” буюу “сөрөг” хариулт сонгосон нь сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ “дундаж” түвшинд үнэлэгдэхэд голчлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалт, нөхөн хангалтын талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ, хувиар:

Асуултауд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ /1-5/	Маш их санал нийлнэ	Их санал нийлнэ	Дунд зэрэг санал нийлнэ	Бага зэрэг санал нийлнэ	ОГТ санал нийлэхгүй
Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн бодлого, түүний хэрэгжилт нь алба хаагч бүр ил тод, нээлттэй, шударгаар албан тушаал дэвших	3281	3,2	410	877	1370	357	267

бололцоог жигд хангасан байдаг гэдэгтэй Та санал нийлэх үү?							
Танай байгууллага алба хаагчдыг албан тушаал дэвшүүлэхэд хүний нөөцөд бүртгэгдсэн байдал, эрэмбэлэгдсэн дарааллын дагуу шударгаар томилдог гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,3	514	1022	1206	283	256
Дундаж оноо	-	3,25	-	-	-	-	-

График 1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалт, нөхөн хангалтын талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:




1.2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын ажлын шилжилт хөдөлгөөн, ажлаас чөлөөлөгдөж буй шалтгаан, нөхцлийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:

Алба хаагчдын ажлын байрны шилжилт хөдөлгөөн, ажлаас чөлөөлөгдөж буй шалтгаан нөхцөлийн талаар алба хаагчдаас 2 төрлийн асуултаар тандаж, үр дүнг нэгтгэхэд 3,15 оноо буюу сэтгэл ханамжийн түвшин “дундаж” үнэлгээтэй гарсан байна. Энэхүү 2 төрлийн асуултад судалгаанд оролцсон нийт алба хаагчдын 424 нь “огт санал нийлэхгүй” буюу “сөрөг” хариулт сонгосон нь сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ “дундаж” түвшинд үнэлэгдэхэд голчлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 3. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын ажлын шилжилт хөдөлгөөн, ажлаас чөлөөлөгдөж буй шалтгаан, нөхцлийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ, хувиар:

Асуултауд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Маш их санал нийлнэ	Их санал нийлнэ	Дунд зэрэг санал нийлнэ	Бага зэрэг санал нийлнэ	Огт санал нийлэхгүй
Таны бодлоор цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчид хэр тогтвор суурьшилтай ажиллаж байна гэж бодож байна вэ?	3281	3,1	277	709	1689	454	152
Таны ажиллаж байгаа нэгжид хүний нөөцийн нөхөн хангалтыг хэр богино хугацаанд нөхөн бүрдүүлдэг вэ?	3281	3,2	357	920	1308	424	272
Дундаж оноо	-	3,15	-	-	-	-	-

График 2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын ажлын шилжилт хөдөлгөөн, ажлаас чөлөөлөгдөж буй шалтгаан, нөхцлийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:




1.3. Алба хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх гол шалтгаан нөхцлийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:

Цагдаагийн алба хаагчийн албандаа хандах хандлага, ялангуяа хариуцсан ажил, мэргэжилдээ эзэн байж, илүү үр бүтээлтэй тогтвор суурьшилтай ажиллах, улмаар байгууллагын хөгжил, цаашдын ирээдүйг тодорхойлоход удирдлагын зүгээс баримталж буй хүний нөөцийн бодлого, алба хаагчдыг идэвхжүүлэх, мотиваци өгөх үйл ажиллагаа ихээхэн чухал үр нөлөөтэй юм.

Алба хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх гол гурван шалтгаан нөхцөлийн талаар 3281 алба хаагчаас авсан санал асуулгын дүнг нэгтгэхэд “гэр бүлийн шалтгаан, ар гэрийн гачигдлаас” гэсэн сонголтыг 1467, “ажлын ачааллаас” гэсэн сонголтыг 1655, “цалин хангамж хүрэлцээгүй байдлаас” гэсэн сонголтыг 1896 алба хаагч тус тус сонгож, голлох гурван шалтгааныг дурдсан байна.

График 3. Алба хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх гол шалтгаан нөхцлийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:



1.4. Алба хаах насны дээд хязгаарт хүрэлгүйгээр цэргийн байнгын тэтгэвэрт эрт гарч байгаа шалтгаан нөхцлийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:

Алба хаагч Алба хаах насны дээд хязгаарт хүрэлгүйгээр цэргийн байнгын тэтгэвэрт эрт гарч байгаа гол гурван шалтгаан нөхцөлийн талаар 3281 алба хаагчдаас авсан санал асуулгын дүнг нэгтгэхэд “тэтгэврийн хувь хэмжээ буурна гэх мэдээллээс” сонголтыг 1297, “ажлын ачааллаас” гэсэн сонголтыг 1714, “эрүүл мэндийн шалтгаанаас” гэсэн сонголтыг 1778 алба хаагч сонгож, голлох гурван шалтгааныг дурдсан байна.

График 4. Алба хаах насны дээд хязгаарт хүрэлгүйгээр цэргийн байнгын тэтгэвэрт эрт гарч байгаа шалтгаан нөхцлийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:



1.5. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны сургалт, түүний үр дүнгийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:


Энэхүү судалгаанд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны сургалт, түүний үр дүнтэй холбоотой сэтгэл ханамжийн түвшинг 2 төрлийн асуултаар тандаж судлахад 3,3 оноо буюу “дундаж”-аас үл ялиг дээгүүр үнэлсэн байна. Судалгаанд оролцсон нийт алба хаагчдын 379 буюу 11,6 хувь нь “огт санал нийлэхгүй”, “сөрөг” хариулт сонгосон нь сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ “дундаж” түвшинд үнэлэгдэхэд голчлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 4. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны сургалт, түүний үр дүнгийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ, хувиар:

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Маш их санал нийлнэ	Их санал нийлнэ	Дунд зэрэг санал нийлнэ	Бага зэрэг санал нийлнэ	Огт санал нийлэхгүй
Алба хаагчдын дунд зохион явуулсан албаны сургалтын чанар, үр дүн нь алба хаагчдын хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,3	373	942	1452	311	203

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас явуулж байгаа цахим, зайны болон танхимын сургалтын арга хэлбэрүүд нь алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд хангалттай байдаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,3	408	949	1433	315	176
Дундаж оноо	-	3,3	-	-	-	-	-

График 5. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны сургалт, түүний үр дүнгийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:




1.6. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хууль тогтоомжийн нийцлийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:

Энэхүү судалгаанд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой сэтгэл ханамжийн түвшинг 2 төрлийн асуултаар тандаж судлахад 3,25 оноо буюу “дундаж”-аас үл ялиг дээгүүр үнэлсэн байна.

Хүснэгт 5. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хууль тогтоомжийн нийцлийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ, хувиар:

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Маш их санал нийлнэ	Их санал нийлнэ	Дунд зэрэг санал нийлнэ	Бага зэрэг санал нийлнэ	Огт санал нийлэхгүй
Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2014 оноос хойш батлагдсан, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хууль нь алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд илүү ойр нийцдэг болсон гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,3	289	1007	1614	271	100
ЦБҮАЖ нь алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагааг илүү нарийвчлан зохицуулж, эрх зүйн зөрчил үүсэх, ойлгомжгүй байдлаас урьдчилан сэргийлж, алба хаагчийн эрх ашгийг хамгаалж чаддаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,2	293	914	1571	332	171
Дундаж оноо	-	3,25	-	-	-	-	-

График 6. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хууль тогтоомжийн нийцлийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:




1.7. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:

Энэхүү судалгаанд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой сэтгэл ханамжийн түвшинг 2 төрлийн асуултаар тандаж судлахад 3,1 оноо буюу “дундаж”-аас үл ялиг дээгүүр үнэлсэн байна.

Хүснэгт 6. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар алба хаагчдын өгсөн үнэлгээ, хувиар:

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Маш их санал нийлнэ	Их санал нийлнэ	Дунд зэрэг санал нийлнэ	Бага зэрэг санал нийлнэ	ОГТ санал нийлэхгүй
Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, удирдлагын тогтолцоо нь маш оновчтой, алба хаагчдын ажлын ачаалал тэнцвэртэй, давхардал хийдэлгүй байдаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,0	235	751	1574	401	320
Цагдаа, дотоодын цэргийн зохион байгуулалтын бүтэц тогтвортой байдаг бөгөөд алба хаагчид тухайн ажил үүрэгт мэргэшихэд илүү дөхөм байгаа гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,2	267	934	1638	304	138
Дундаж оноо	-	3,1	-	-	-	-	-

График 7. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ:



1.8. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын стратеги, хөгжлийн хөтөлбөрийн талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:


Энэхүү судалгаанд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын стратеги, хөгжлийн хөтөлбөртэй холбоотой сэтгэл ханамжийн түвшинг 4 төрлийн асуултаар тандаж судлахад 3,2 оноо буюу “дундаж”-аас үл ялиг дээгүүр үнэлсэн байна. Судалгаанд оролцсон нийт алба хаагчдын 681 буюу 20,8 хувь нь эдгээр 4 асуултад “огт санал нийлэхгүй”, “сөрөг” хариулт сонгосон нь сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ “дундаж” түвшинд үнэлэгдэхэд голчлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 7. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын стратеги, хөгжлийн хөтөлбөрийн талаар алба хаагчдын өгсөн үнэлгээ, хувиар:

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Маш их санал нийлнэ	Их санал нийлнэ	Дунд зэрэг санал нийлнэ	Бага зэрэг санал нийлнэ	Огт санал нийлэхгүй
Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр нь бусад байгууллагуудын хөгжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулахад	3281	3,3	287	983	1583	278	150

илүү сайн хэрэгждэг гэдэгтэй Та санал нийлэх үү?							
Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр нь алба хаагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаа гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,1	251	827	1642	375	186
Цагдаагийн байгууллага нь батлагдсан хөгжлийн хөтөлбөрийг чанд мөрдөж ажилладаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,3	298	1013	1546	296	128
Цагдаагийн байгууллагаас сүүлчийн 10 жил хэрэгжүүлсэн хүний нөөцийн хөгжлийн бодлого нь маш оновчтой байсан гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,1	241	870	1603	350	217
Дундаж оноо	-	3,2	-	-	-	-	-

График 8. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын стратеги, хөгжлийн хөтөлбөрийн талаар алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ:




1.9. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны сургалт, соён гэгээрүүлэх ажлын талаар алба хаагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ:

Энэхүү судалгаанд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны сургалт, соён гэгээрүүлэх ажилтай холбоотой сэтгэл ханамжийн түвшинг 4 төрлийн асуултаар тандаж судлахад 3,3 оноо буюу “дундаж”-аас дээгүүр үнэлсэн байна. Судалгаагаар давхардсан тоогоор 6127 алба хаагч эдгээр 4 асуултад “дунд зэрэг санал нийлнэ” хариулт сонгосон нь сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ “дундаж” түвшинд үнэлэгдэхэд голчлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 8. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны сургалт, соён гэгээрүүлэх ажлын талаар алба хаагчдын өгсөн үнэлгээ, хувиар:

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Маш их санал нийлнэ	Их санал нийлнэ	Дунд зэрэг санал нийлнэ	Бага зэрэг санал нийлнэ	Огт санал нийлэхгүй
Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулж буй сургалт нь нийт алба хаагчдад хүртээмжтэй, хэрэгцээ шаардлагыг бүрэн хангадаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,3	300	978	1543	332	158
Алба нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй дотоод сургалт нь алба хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэхэд чухал үр дүнтэй байдаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,3	308	980	1548	305	140
Дотоод хэргийн их сургуульд элсэн суралцаж, төгссөн алба хаагчид ажлын байранд шууд ажиллахад бүрэн бэлтгэгдэж, дадлагажсан байдаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,2	339	874	1515	382	171
Гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцах, бусад хэлбэрээр өөрийгөө хөгжүүлснээр дээд шатны байгууллага, албан тушаалтны зүгээс тухайн алба хаагчийг албан тушаал дэвших, ажлын үр дүнгийн үнэлгээг дээшлүүлэх эерэг үзүүлэлт болгон авч үздэг гэдэгтэй Та санал нийлэх үү?	3281	3,3	311	1030	1521	273	146
Дундаж оноо	-	3,3	-	-	-	-	-

График 9. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны сургалт, соён гэгээрүүлэх ажлын талаар алба хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ:



1.10. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хүний нөөц, боловсон хүчний бодлого, албаны сургалтыг сайжруулах чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үздэг вэ гэсэн чөлөөт асуултад судалгаанд оролцсон нийт 3281 алба хаагчаас 103 алба хаагч ямар нэгэн санал хүсэлт бичсэн боловч ихэнх нь буюу 75 хариулт нь “мэдэхгүй”, “байхгүй”, “ок”, “хэвийн”, “санал алга, саналгүй”, “болж байна” гэх мэт идэвхгүй, сул хариулт өгсөн бол 20 гаруй хариулт нь “сургалтыг цахим болгох”, “цалин нэмэх” гэх мэт товч хариулт өгсөн байна.